



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудит хийх үндэслэл: Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга, Монгол улсын Ерөнхий аудитор нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Уран бүтээлийн маркетинг зөв тодорхойлж хэрэгжүүлснээр үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, улмаар тоглолтын орлого нэмэгдэх боломжтой байна.



Аудитын нэр:

**“Сүхбаатар аймгийн хөгжимт жүжгийн театрын
2016 оны үйл ажиллагааны үр дүн”**

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

Сүхбаатар аймаг
дахь Төрийн
аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор М.Нарантуяа

Аудитын
менежер Г.Даваа

Ахлах аудитор Г.Оюунболд
Аудитор О.Барчидгүнсэн
Аудитор Э.Алтансүх

2017 оны 07 дугаар сарын 19-ний
өдөр

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал багийн утас 70512123,
70512127

Газрын дарга, тэргүүлэх аудитор
70518396 дугаарын факсаар
харилцана уу

ХАЯГ:

Аймгийн аудитын газар Баруун-Урт
сум 7-р баг Төрийн захиргааны
байр өрөө №226 тоот

Сүхбаатар аймаг
Баруун-Урт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, 3
шалгуур үзүүлэлт
Товчилсон үгийн тайлбар 3

1.1. Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг ТЕЗ
дүгнээгүй байна. 4

1.2. Байгууллагын үйл ажиллагааны зорилго,
зорилт, уран бүтээлийн төлөвлөгөөний зарим
заалтууд биелээгүй байна. 5

2.1. Өөрийн орлогыг цаг хугацаанд нь тушаагаагүй
байна. 6

2.2. Уран бүтээлийн маркетинг зөв тодорхойлж
хэрэгжүүлснээр үзэгчдийн тоог нэмэгдүүлэх,
улмаар тоглолтын орлого нэмэгдэх боломжтой
байна. 7

3.1. Урамшууллын зардлыг төлөвлөж батлуулаагүй
учир албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр нь
урамшуулаагүй байна. 8

3.2. Уран бүтээлийн зардлаас “Уран бүтээлийн
шагнал” гэх нэршилээр 4 албан хаагчид
урамшуулал олгож, төсвийг зориулалт бус
зарцуулсан. 8

3.3. Хувцас бүрт нягтлан бодох бүртгэлийн кодноос
гадна дэс дараалсан, төрөлжүүлсэн ялгамжтай код
тогтоох хэрэгцээ шаардлага үүсчээ.

Аудитын дүгнэлт: 1
0

Аудитын зөвлөмж:

Холбогдох байгууллагын санал

Аудитын газрын тайлбар 1
2

1
2

1
-

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл

Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга, Монгол улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аудитын зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгөв. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны үр дүн
- Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Төсвийн зарцуулалт, үр дүн, НББ-ийн хөтлөлт

Аудит хамарсан хүрээ

Сүхбаатар аймгийн хөгжимт жүжгийн театрын 2016 оны борлуулалтын орлого, санхүүгийн баримт материал, бодлогын бичиг баримт, үйл ажиллагааны холбогдох баримт материалын хүрээнд шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХЖТ	Хөгжимт жүжгийн театр
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Дэд зорилт-1. Үндсэн үйл ажиллагааны үр дүн.

1

БҮЛЭГ 1

Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг дүгнээгүй байна.

Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг ТЕЗ дүгнээгүй байна.

1.1.1. Аймгийн засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд үндсэн дөрвөн зорилтыг дэвшүүлэн ажилласан бөгөөд “Шинэ зууны эрэлт хэрэгцээ, улс орны хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн өөрийн онцлогийг тусгасан урын сангийн бодлого баримталж, оновчтой тогтолцоог бүрдүүлнэ” нэгдүгээр зорилтын хүрээнд зургаан төрлийн тоглолтыг зохион байгуулахаар тусгажээ. Үүнээс Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн “Гэгээн тамлан”, хүүхдийн харшийн сүлд модны наадам, эх үрсийн баярт зориулан “Туулай бар болсон нь” хүүхдийн жүжиг, Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан сумдуудад аялан тоглолт, Дорнод аймгийн Хөгжимт драмын театрт хамтарсан “Нарны орон” нэгдсэн тоглолтыг Хэнтий, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад зохион байгуулсан байна. Дарьгангын язгуур урлагийн концертын хувьд бэлтгэл ажил хангагдсан боловч санхүүгийн боломжгүйгээс тайзнаа тавигдаагүй байна.

1.1.2 Уран бүтээлийн тоглолтыг аймаг, сумдад тоглож үзэгчдийн хүртээл болгосон нь сайшаалтай боловч аймгийн төвд үзэх үзэгчдийн тоо багассан байна. Гаднаас ирж тоглосон уран бүтээлийн тоглолтуудтай харьцуулахад тус байгууллагын уран бүтээлийг үзэх үзэгчдийн тоо буурсан. Энэ нь уран бүтээлийг чанаржуулах, үзэгчдийн сонирхолд нийцүүлэх, уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэх, уран бүтээл хийхэд шаардагдах суурь судалгааг оновчтой зохион байгуулж ажиллах шаардлага үүссэнийг харуулж байна.

1.1.3. “Олон улс, бүс нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж байр сууриа бэхжүүлнэ” дөрөвдүгээр зорилтын хүрээнд орон нутгийн байгууллагатай хамтран хүүхдийн эрхийн тухай зохиолоор драмын жүжиг, хүчний байгууллагатай хамтарсан тоглолт, “Бас л завгүй” Монголын шүлэг найрагчтай хамтарсан арга хэмжээг зохион байгуулж, гэрээнд тусгасан дэд зорилтуудыг хэрэгжүүлсэн боловч ерөнхий менежер үр дүнгийн гэрээг дүгнээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилт, уран бүтээлийн төлөвлөгөөний зарим заалтууд биелээгүй байна.

1.2.1. Аймгийн ХЖТ нь 2016 онд “Дорнод монголын ард түмний уламжлалт, ёс, зан заншлын давтагдашгүй онцлогийг орчин үеийн дэвшилтэт ололтоор баяжуулан хөгжүүлсэн, Монгол Улсын соёл урлагийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, хүний оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц уран бүтээлээр үзэгчдэд үйлчлэхэд оршино” зорилт дэвшүүлэн ажилласан.

1.2.2. Дээрх зорилгыг хангаж ажиллах хүрээнд ерөнхий менежер үр дүнгийн гэрээнд холбогдох уран бүтээлийг үзэгчдийн хүртээл болгох зорилтуудыг дэвшүүлж, байгууллагын бүтээмжийг дээшлүүлж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох байгууллагын орчинг олон улсын жишигт хүргэх, техник хэрэгслийг шинэчлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэх, үзэгч болон уран бүтээлч, ажиллагсад таатай орчинг бүрдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой уран бүтээлүүдийг үзэгчдийн хүртээл болгожээ.

1.2.3. Харин олон улс, бүс нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагатай хамтран ажиллах гэж заасан дөрөвдүгээр зорилтын хүрээнд 3 уран бүтээл төлөвлөсөн ч дээрх зорилттой нийцээгүй, уг зорилт хэрэгжээгүй байна. Тухайлбал “хүний эрхийн тухай зохиолоор тавилттай уншилт бүхий драмын жүжгийг тайзнаа тоглох, хүчний байгууллагатай хамтарсан тоглолтыг зохион байгуулах, “Бас л завгүй” Монголын шүлэг найрагчтай хамтарсан арга хэмжээг зохион байгуулах ажлыг төлөвлөсөн боловч төсөв хөрөнгийн хүрэлцээгүйгээс хэрэгжээгүй. Цаашид байгууллагын төсөв хөрөнгө, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан хэрэгжих боломжтой зорилтыг дэвшүүлж, зохион байгуулах нь зохимжтой юм.

1.2.4. Тус байгууллагын даргын 2016 оны 07 сарын 22-ны өдөр А/12 тоот тушаалд Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1, “Хөгжимт жүжгийн театрын захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулах 2015-2016 оны хамтын гэрээ”-ний 3.3 дахь заалтыг үндэслэл болгон сул зогсолтын олговор олгосон байна. Байгууллагын үйл ажиллагаанд сул зогсолт үүссэн шалтгаан нөхцөлийг холбогдох албан тушаалтнуудаас тодруулахад “Энэ нь мэргэжлийн урлагийн байгууллагын онцлогтой холбоотой бөгөөд ахмад ажилтнууд залуу ажилтнуудыг бодвол ээлжийн амралтын хоног илүү байдаг тул залуу ажилтнууд түрүүлж ороод хийх зүйл байдаггүй учир сул зогсолт хийх нь зохистой байдаг” гэсэн тайлбарыг өгсөн.

1.2.5. Дээрхээс харахад сул зогсолт үүсэх бодит нөхцөл байдал үүсээгүй байхад сул зогсолт зарласан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 15.1.2¹ дахь заалтыг зөрчсөн. Мөн “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”, 2016 оны батлагдсан төсөв, төсвийн хуваарийг авч үзэхэд сул зогсолт зарлах шалтгаан нөхцөл харагдахгүй байна.

¹ Ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцохыг хориглоно.

1.2.6. Иймд төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн жигд байх зарчмыг баримтлан ажиллаж, сул зогсолт гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

Дэд зорилт-2. Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

2

БҮЛЭГ 2

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогод тавих хяналт сул байна.

Өөрийн орлогыг цаг хугацаанд нь тушаагаагүй байна.

2.1.1. Гадны байгууллага, хувь хүмүүст заал түрээслүүлсэний орлого /цаашид шимтгэлийн орлого гэх/-ын төлөвлөгөөг батлаагүй боловч 2016 онд 12.4 сая төгрөгийн шимтгэлийн орлого олжээ.

2.1.2. Шимтгэлийн орлого төвлөрүүлж байх жишиг гэрээг 2016 оны 01 сарын 11 өдрийн Захиралын зөвлөлийн хуралдаанаар баталсан хэдий ч гэрээний нөхцөлд заагдаагүй хөнгөлөлтийг гадны уран бүтээлчдэд үзүүлж 1.9 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжийг алдсан байна.

2.1.3 Мөн орлого бүрдэлтийн байдалд бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй хэрэгжиж байна. Тухайлбал нягтлан бодогч шимтгэлийн болон гэрээний орлогын тооцоог тухай бүр хийж, хяналт тавьдаггүйгээс 9.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлбэл зохих хугацаанаас 10 хоногоос 9 сарын дараа төсвийн харилцах дансанд төвлөрүүлсэн зөрчил дутагдал илэрсэн.

- *Тухайлбал: 2016 оны 03 сарын 03-ны өдөр тоглосон “Жаргалтай айл манайх” тоглолтын шимтгэл 0.7 сая төгрөгийг 05 сарын 18 өдөр, 03 сарын 07 өдөр тоглосон “Ачыг тань мөнхөд санана” тоглолтын шимтгэл 1.5 сая төгрөгийг 12 сарын 16-ны өдөр тус тус тушаасан байна.*

2.1.4. Орлогыг цаг хугацаанд нь тушаагаагүй нь НББ-ийн тухай хуулийн 19.3² дахь заалт, 20.2.6³, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн

² Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд ерөнхий (ахлах) нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурна.

³ Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах

байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6⁴, 3.13⁵ дахь заалтыг тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

Уран бүтээлийн маркетинг зөв тодорхойлж хэрэгжүүлснээр үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, улмаар тоглолтын орлого нэмэгдэх боломжтой байна.

2.2.1. Үндсэн үйл ажиллагааны орлого 31.5 сая төгрөгөөр төлөвлөгдөж гүйцэтгэлээр 12 уран бүтээлийн үзвэрийн орлого 17.4 сая, хувцас түрээсийн орлого 0,6 сая нийт 18 сая төгрөгийн орлого төвлөрч 57 хувийн биелэлттэй гарчээ. Үзвэр үйлчилгээний 25.4 сая төгрөгийн билет хэвлэснээс 17.4 сая төгрөгийн орлого төвлөрч, үлдэгдлийг авлагаар илэрхийлжээ. Билетийн тооллого тооцоог хийхэд 2.2 сая төгрөгийн орлогыг бүртгээгүй, дутуу төвлөрүүлсэн зөрчил дутагдал илэрсэн тул төлбөрийн акт тогтоолоо.

2.2.2. Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого 2015 онд 51.8 сая төгрөг 2016 онд 32.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оноос 19.2 сая төгрөгөөр буурчээ. Энэ нь нийтийн номын сангийн түрээсийн орлого 2016 онд ороогүйтэй⁶ холбоотой байна.

2.2.3. Санхүүгийн тайлангийн аудитаар *“Билетийг урьдчилан дугаарлаж, улмаар таслагдсан билетийг үндэслэн борлуулалтын орлого, дансны авлагыг бүртгэлд тусгаж байх”* зөвлөмжийг өгсөн боловч үнэт цаас болох билетийг дугаарлаж хэвшээгүй, тоглолт бүрийн дараа нягтлан бодогч тооцоо боддоггүй алдаа, зөрчил арилаагүй байна.

2.2.4 Өөрийн байгууллагын бүх уран бүтээлийг төлбөртэй тоглож байгаатай холбоотойгоор үзэгчдийн тоо хангалттай хэмжээнд хүрдэггүй, улмаар борлуулалтын орлогын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд байгууллагуудад билетийг урьдчилан тарааж дараа нь мөнгөө авдаг байдлаар ажиллаж байна. Борлуулалтын энэ хэлбэр нь 1-рт үзэгчдийн тоог хангалтгүй түвшинд байлгахад нөлөөлдөг, 2-рт борлуулалтын орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой дээрх алдаа, зөрчил гарах үндсэн суурь шалтгаан нөхцөл болжээ.

2.2.5 Иймд үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогыг өмнөх онуудын түвшингээс бууруулахгүйгээр үзэгчдийн тоо, уран бүтээлийн чанар, хүртээмж, тоглох давтамжийг нэмэгдүүлэх боломжтой дараах шийдлийг санал болгож байна. Тодруулбал: Үзэгч, үйлчлүүлэгч нарт өөрийн уран бүтээлийг жилийн тодорхой хугацаанд үнэ төлбөргүй хүргэж, эхний хагас жил болон жилийн эцэст шилмэл уран бүтээл, номеруудаар төлбөртэй үйлчлэх бодлогыг баримтлах нь зүйтэй.

⁴ Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа/бусад орлого/-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг/түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.

⁵ Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын /зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь/тооцоог гаргаж, тайланг тушаана.

⁶ Нийтийн номын сан халаалтын төлбөрөө Дөрвөлж ОНӨҮГ уруу шууд шилжүүлдэг болсонтой холбоотой.

2.2.6 Мөн түүнчлэн дээрх санал, зөвлөмжийг хэрэгжүүлснээр билет кассаар 100 хувь борлогддог болж, улмаар борлуулалтын орлогын бүрдэлт, тушаалтын байдалд хяналт тавих орчин нөхцөл бүрдэнэ. Үзэгчдийн тоо хангалттай түвшинд хүрсэн тохиолдолд уран бүтээлийн тоглолтын дундуур зохих хэмжээний төлбөртэй сурталчилгаа, мэдээллийг хүргэж, орлогын нэр төрлөө нэмэгдүүлэх бололцоотой.

3

Дэд зорилт-3 Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүн, НББ-ийн хөтлөлт.

БҮЛЭГ 3

Урамшууллын зардлыг төлөвлөж батлуулаагүй, уран бүтээл хийлгэх зардлыг зориулалт бус зарцуулсан байна.

Урамшууллын зардлыг төлөвлөж батлуулаагүй учир албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр нь урамшуулаагүй байна.

3.1.1. Тус байгууллагын 2016 оны төсвийн төслийн төлөвлөлтийг орлого, зардлын нэр төрлөөр гүйцэтгэлтэй нь харьцуулан авч үзэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Орлого: Байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелэсэн боловч үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 43 хувиар тасарсан. Үндсэн үйл ажиллагааны орлогын дутуу биелэлтийг үндсэн бус үйл ажиллагааны орлого болох гадны байгууллага, хувь хүмүүст заал түрээслүүлсэний орлогоор нөхсөн байна. Үндсэн бус үйл ажиллагааны орлого жил бүр төвлөрдөг боловч 2016 оны төсвийн төсөлд тусгаагүй байна.
- Зардал: Урамшууллын зардлыг төсөвлөөгүй нь албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр нь урамшуулах нөхцлийг бүрдүүлээгүй байна.

3.1.2 Иймд “Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох тухай журам”-ын 5-д заасны дагуу албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр урамшуулахын тулд “урамшуулал”-ын зардлыг төсвийн төсөлд тусгаж, батлуулах; үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг өмнөх жилүүдийн гүйцэтгэлийг үндэслэн бодитой төлөвлөх, гадны байгууллага хувь хүмүүсийн уран бүтээлийн шимтгэлийн орлогыг өмнөх жилүүдийн дунджаар төсвийн төсөлд тусгах шаардлагатай байна.

Уран бүтээл хийлгэх зардлаас “Уран бүтээлийн шагнал” гэх нэршилээр 4 албан хаагчид урамшуулал олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан.

3.2.1. Гэгээрлийн сайдын 1999 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.11⁷ дахь заалтыг

⁷ 2.11. Өөрийн үйл ажиллагаа, уран бүтээл, уран бүтээлчдийн тухай гадаад дотоодод сурталчлах, тэргүүний хүмүүсийг алдаршуулах, дэмжих **урамшуулах**, өөрийн байгууллага, уран бүтээлчдийн нөөц бололцоо, авьяас чадавхад тулгуурлан бие даасан үйл ажиллагаа явуулах.

үндэслэн тус байгууллагын “Уран сайхны зөвлөл”-ийн 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5 дугаар тогтоол гарсан байна. Уг тогтоолын дагуу уран бүтээлийн шагнал гэх нэршилээр 4 албан хаагчид 0.2-3.1 сая төгрөгийн нийт 4.4 сая төгрөгийн урамшуулалыг уран бүтээл хийлгэх зардлаас олгосон. Үндэслэл болгосон дээрх дүрмийн холбогдох заалт нь мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон бөгөөд албан хаагчид шагнал, урамшуулал олгохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй. Харин төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгохтой холбоотой харилцаа нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6-р хавсралт “Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох тухай журам”-аар зохицуулагддаг. Иймд дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах зөрчил дутагдал гарчээ. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардал /уран бүтээл хийлгэх зардал⁸/-аас уран бүтээлийн шагнал гэх нэршилээр зардал гаргаж, 4 албан хаагчийг урамшуулсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай нийцэхгүй бөгөөд 4.4 сая төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5⁹ дахь заалтыг зөрчжээ.
- “Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох тухай журам”-ын 5-д “...төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно.” гэж заасны дагуу урамшуулаагүй. Энэ нь төсвийн төсөлд холбогдох зардлыг дутуу тусгасантай холбоотой байна.

3.2.2. Иймд төсвийг зориулалт бус зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр нь албан тушаалын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр урамшуулахад шаардагдах зардлын төсвийг жил бүр төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

3.2.3. Тус байгууллагад урьд нь ажиллаж байсан Дугаржав овогтой Батхуяг нь “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд хийгдэх дөрвөн талт гэрээ”¹⁰-ний дагуу Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд “Мужааны анги”, “Сургах зүйн чадамж эзэмшүүлэх” сургалтад тус тус хамрагдсан бөгөөд түүнийг суралцаж байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас 21¹¹ хувиар төлсөн байна. Мөн ХЖТ-ын 2016 оны төсвийн төсөлд Д.Батхуягийн тэтгэлгийн мөнгийг тусгаж явуулсан нь батлагдсан. Улмаар энэ аудитын хугацаанд уг тэтгэлгийг олгогдох гэж байсныг зогсоосон. Тодруулбал: Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1997 оны 197/232 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Соёлын

⁸ Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-аас авч үзвэл 210814 кодтой “Уран бүтээл хийлгэх”-ын зардлын хувьд Соёл, урлагийн байгууллагуудын уран бүтээл хийх зардал, бэлтгүүлэхтэй холбоотойгоор гарах зардлуудыг энэ ангилалд бүртгэнэ.

⁹ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

¹⁰ 2014 оны 02 сарын 07-ны өдрийн 53 дугаартай

¹¹ Д.Батхуягийг ажилд авсан тушаал гарсан боловч огт ажиллаагүй бөгөөд цалин олгоогүй байхад тус байгууллагаас 21 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

ажилтныг тэтгэвэрт гарахад нь тэтгэлэг олгох журам"-ын 1.2¹² дахь заалттай нийцэхгүй байгаа тул дээрх тэтгэлгийг олгохгүй байх тухай албан шаардлага хүргүүлээ.

3.2.4. Тус байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, мэдээг сар бүрийн цалингийн цэстэй тулган шалгахад 2,209.4¹³ мянган төгрөгийн цалингаас НДШ, ХХОАТ суутгаагүй зөрчил илэрлээ. Мөн 2017 оны 1, 2, 8, 10 сарын нийгмийн даатгалын тайлангийн дүн, цалингийн цэсний дүнгээс 112.6-1,732.9 мянгаар илүү, 4, 11, 12 сарынх 96.0-249.2 мянган төгрөгөөр дутуу байна.

3.2.5. Иймд ХХОАТ-т суутгаагүй 198.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 3,023.7 мянган төгрөгийн зөрчил болон цалин бодогдоогүй хүний нэр дээр 21 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн зөрчлийг Сүхбаатар аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээр шалгуулах саналыг албан бичгээр хүргүүллээ.

Хувцас бүрт нягтлан бодох бүртгэлийн кодноос гадна дэс дараалсан, төрөлжүүлсэн ялгамжтай код тогтоох хэрэгцээ шаардлага үүсчээ.

3.3.1. Тус байгууллагын хувцасны бүртгэл, тооллоготой холбоотой асуудлаар аудитын явцад дараах санал, гомдол¹⁴ ирсэн. Үүнд:

- Данс бүртгэлд байгаа боловч дутагдсан гэх хувцас-202 ширхэг, 3,622.6 мянга,
- Нэр тодорхойгүй болон огт байгаагүй хувцас данс бүртгэлд бүртгэсэн гэх -250 ширхэг, 5,605.3 мянга,
- Нэг бүрийн үнэ буюу анхны өртөг зөрүүтэй гэх хувцас – 166 ширхэг, 1,695.8 мянга,
- Дансанд буруу ангилагдан бүртгэгдсэн гэх хувцас – 105 ш, 3,272.3 мянга,
- Данс бүртгэлд байхгүй боловч биетээр тоологдсон гэх хувцас – 497 ширхэг, 10,016.3 мянга

3.3.2. Нийт 24,212.3 мянган төгрөгийн зөрчил, 174 ширхэг, 4,207.8 мянган төгрөгийн хувцасыг актлах буюу данснаас хасах шаардлагатай гэж үзээд тус байгууллагын “Захиралын зөвлөлийн хурал”-аар 2016 оны 11 сарын 14-нд хэлэлцүүлсэн боловч тус хурлаар гаргасан шийдвэр тодорхой бус гэх шалтгаанаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй¹⁵ байна. Мөн тус байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл¹⁶ хувцасны бүртгэлтэй холбоотой дээрх асуудлын талаар авч хэлэлцээгүй, хурал хийгээгүй байна. Аудитын хугацаанд хувцасны бүртгэл, тооллоготой холбоотой асуудлыг нягтлах хяналтын тооллого хийх боломжгүй байсан. Тодруулбал: Аудитын хугацаанд хувцастай

¹² Соёлын ажилтанг тэтгэвэрт гарахад нь тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс буюу түүнтэй адитгах орлогын нэг жилийн дундажтай тэнцэх хэмжээний тэтгэлэгийг ажиллаж байсан байгууллага нь нэг удаа олгоно.

¹³ 2,209,391 төгрөг

¹⁴ ХЖТ-ын даргын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/03 тоот тушаалын дагуу борлуулалт түгээлтийн менежер Г.Тунгалаг, хувцасны эрхлэгч Л.Эрдэнэчимэг нар тоглолтын хувцасанд тооллого хийсэн байна

¹⁵ Данс бүртгэлд байхгүй боловч биетээр тоологдсон гэх хувцасыг данс бүртгэлд авч эхэлсэн гэх тайлбарыг эс тооцвол ямар нэгэн бодит арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

¹⁶ Сүхбаатар аймгийн Хөгжимт жүжгийн театрын даргын 2016 оны 11 сарын 21-ний өдрийн А/19 тоот “Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” тушаалаар тус байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл шинэчлэн байгуулагдсан байна.

холбоотой гомдол гаргасан ажилтан эмчилгээнд явсан, хувцас бүр тусгайлсан кодгүй, хувцаснууд өөр хоорондоо ижил төстэй, зарим хувцасны нэр нягтлан бодох бүртгэлийн дансанд ерөнхий нэршилээр бүртгэгдсэн зэрэг хүчин зүйл нөлөөлсөн.

3.3.3. Иймд дээрх нөхцөл байдлыг дүгнээд хувцас бүрт нягтлан бодох бүртгэлийн кодноос гадна дэс дараалсан, төрөлжүүлсэн ялгамжтай код өгч, хувцас бүрийн дотор талд оёж тогтоох хэрэгцээ шаардлага үүссэн байна гэж үзлээ. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хувцасны тооллого хийх, бүрэн бүтэн байдалд хяналт тавихад хялбар, ойлгомжтой болох тул энэ талаар зөвлөмж өглөө. Харин тус байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга, гишүүд үүрэгт ажлаа хангалтгүй хэрэгжүүлсэн тул тэдгээрт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ. Мөн тооллогын комиссыг шинээр томилж хувцасыг дахин чанартай тоолж, данс бүртгэлтэй холбоотой зөрчил дутагдлыг шийдвэрлэж, хариу мэдэгдэх тухай албан шаардлага хүргүүлсэн.

3.3.4. Тайлант онд хийгдсэн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор данс бүртгэлд байгаа 1998 оны 01 сарын 02-ны өдөр ашиглалтад орсон 1,950.0 мянган төгрөгийн үнэтэй автобус¹⁷ дутагдсан болохыг тогтоож, дутагдуулсан үндсэн хөрөнгийн жилийн мэдээнд тусгасан байна. Уг хөрөнгийг дутагдуулсан шалтгаан нь тодорхой бус байна. Иймд Авто тээврийн үндэсний төвийн Сүхбаатар аймаг дахь салбарт хандаж ХЖТ-ын нэр дээр 1998 оноос хойших бүртгэлтэй байсан болон байгаа авто тээврийн хэрэгслүүдийн нэр төрөл, өнгө, арлын дугаар, эзэмшигчийн нэр, номер дугаар зэрэг мэдээллээр лавлагаа гаргуулж авах. Улмаар дутагдуулсан гэх автобусыг хамгийн сүүлд ямар байгууллага, хувь хүн эзэмшиж, ашиглаж байсныг тодорхой болгосны дараа Орон нутгийн өмчийн газарт зохих журмын дагуу хандаж, уг автобустай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өглөө.

---o0o---

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Сул зогсолт үүсэх бодит нөхцөл байдал үүсээгүй байхад сул зогсолт зарласан нь Төрийн албаны тухай хуулийн 15.1.2 */ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцохыг хориглоно./* дахь заалтыг зөрчжээ.

¹⁷ Хөрөнгийн ангилалын код-49112, байгууллагын хөрөнгийн дугаар-512.

- ❖ Уран бүтээлийн маркетинг зөв тодорхойлж хэрэгжүүлснээр үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, улмаар тоглолтын орлого нэмэгдэх боломжтой байна.
- ❖ Урамшууллын зардлыг төлөвлөж батлуулаагүй учир албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр нь урамшуулаагүй, уран бүтээл хийлгэх зардлаас “Уран бүтээлийн шагнал” гэх нэршилээр 4 албан хаагчид урамшуулал олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

- ❖ Өөрийн уран бүтээлийг үзэгч, үйлчлүүлэгч нарт жилийн тодорхой хугацаанд үнэ төлбөргүй хүргэж, эхний хагас жил болон жилийн эцэст шилмэл уран бүтээл, номеруудаар төлбөртэй үйлчлэх бодлогыг баримтлах
- ❖ “Урамшуулал”-ын зардлыг төсвийн төсөлд тусгаж, батлуулан, улмаар “Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох тухай журам”-ын 5-д заасны дагуу албан хаагчдыг улирлын ажлын дүнгээр урамшуулж ажиллах.
- ❖ Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг өмнөх жилүүдийн гүйцэтгэлийг үндэслэн бодитой төлөвлөх, гадны байгууллага хувь хүмүүсийн уран бүтээлийн шимтгэлийн орлогыг өмнөх жилүүдийн дунджаар төсвийн төсөлд тусгах.
- ❖ Хувцас бүрт дэс дараалсан, төрөлжүүлсэн ялгамжтай кодтой болгох
- ❖ Авто тээврийн үндэсний төвийн Сүхбаатар аймаг дахь салбарт хандаж ХЖТ-ын нэр дээр 1998 оноос хойшхи бүртгэлтэй байсан болон байгаа авто тээврийн хэрэгслүүдийн нэр төрөл, өнгө, арлын дугаар, эзэмшигчийн нэр, номер дугаар зэрэг мэдээллээр лавлагаа гаргуулж авах.

---o0o---

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

СҮХБААТАР АЙМГИЙН
ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН ТЕАТР22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518211, 705182212017.07-19 № 71
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагын 2016 оны үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авч цаашид зөрчил дутагдалгүй ажиллах шийдвэр гаргасныг хүргүүлж байна.



Б.БАТСАЙХАН

СБР-2017/01-ГА
Гүйцэтгэлийн аудитын тайлан

Хөгжимт жүжгийн театрын 2016 оны үйл жиллагааны үр дүн

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-дэх заалтын дагуу "Сүхбаатар аймгийн хөгжимт жүжгийн театрын 2016 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал авахаар хүргүүлсэн.

Сүхбаатар аймгийн Хөгжимт жүжгийн театр 2017 оны 07 сарын 19-ны өдрийн 71 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн саналд дараах тайлбар хийлээ. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй ба дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзэв.

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Г.Оюунболд

Тэргүүлэх аудитор

М.Нарантуяа

Аудитор

О.Барчидгүнсэн

Аудитын менежер

Г.Даваа

Аудитор

Э.Алтансүх

Хянасан:



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/07

Баруун-Урт

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, 11, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Хөгжимт жүжгийн театрын 2016 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар тогтоосон акт, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэхийг Хөгжимт жүжгийн театрын дарга /Б.Батсайхан/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2017/tushaal

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторовын 2017 оны 07 сарын
19-ны өдрийн А.1.2-тоот тушаалын хавсралт

“Сүхбаатар аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2016 оны
үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

Дугаар	Акт, албан шаардлагын төрөл, код		Алдаа, зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1/47	Акт	СБР-2017/01 -ГА	Цалингаас ХХОАТ-т суутгавал зохих 198,800 төгрөгийг суутгаагүй.	ХХОАТ-т суутгаагүй 198,800 төгрөгийг холбогдох албан албан хаагчаар төлүүлэх	0.2
2/48	Акт	СБР-2017/01 -ГА	Үндсэн үйл ажиллагааны орлого буюу тоглолтын орлогоос 2261500 /Хоёр сая хоёр зуун жаран нэг мянга таван зуун/ төгрөгийн орлогыг бүртгээгүй, дутуу төвлөрүүлсэн.	Төвлөрүүлээгүй 2261500 төгрөгийг холбогдох албан албан хаагчаар төлүүлэх	2.3
1/60	Албан шаардлага	СБР-2017/01 -ГА	Сул зогсолт зарлах бодит нөхцөл байдал үүсээгүй байхад сул зогсолт зарласан.	Төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн жигд байх зарчмыг баримтлан ажиллаж, сул зогсолт гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	-
2/61	Албан шаардлага	СБР-2017/01 -ГА	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардал /уран бүтээл хийлгэх зардал/-аас уран бүтээлийн шагнал гэх нэршилээр зардал гаргаж, 4 албан хаагчийг урамшуулж төсвийг зориулалт бус зарцуулсан	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах	4.4
3/62	Албан шаардлага	СБР-2017/01 -ГА	Ажиллаагүй буюу цалин олгогдоогүй хүний нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас 21 хувиар төлж, НДДэвтэрт бичилт хийсэн, улмаар тухайн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан гэж үзэн тэтгэлэг олгох гэж байсан	Хууль тогтоомжид нийцэхгүй байгаа уг тэтгэлгийг олгохгүй байх,	4.6
4/63	Албан шаардлага	СБР-2017/01 -ГА	Тоглолтын хувцасны бүртгэл, тооллоготой холбоотой 24,212.3 мянган төгрөгийн бүрэн гүйцэд шийдвэрлээгүй	Тооллогын комиссыг шинээр томилж хувцсыг дахин чанартай тоолж, данс бүртгэлтэй холбоотой зөрчил дутагдлыг шийдвэрлэх	24.2
5/64	Албан шаардлага	СБР-2017/01 -ГА	Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны 24.9 сая төгрөгийн орлогыг касс болон харилцах дансанд цаг хугацаанд нь төвлөрүүлээгүй	Уг зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	24.9
6/65	Албан шаардлага	СБР-2017/01 -ГА	Өмч хамгаалах байнгын зөвлөл хангалтгүй ажилласан. Мөн нягтлан бодогч нь үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын биелэлтэд бүртгэлээр хяналт тавьж ажиллаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан мэдээг зөрүүтэй гаргасан	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчдад сахилгын хариуцлага тооцож, биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх	-